



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/148

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.а, 29.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн гуравдугаар хуралдааны 3/03 дугаар төсөв батлах тухай тогтоолын 4.28 дахь хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд хотын хуучин нийтийн орон сууцны барилгын гадна фасад засварын ажилд зориулан 400.4 сая төгрөгийг хавсралтаар батлан, зарцуулсугай.

2. Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу шуурхай зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Худалдан авах ажиллагааны албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Батсүх/ нарт үүрэг болгосугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний зардлыг Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.28-д тусгагдсан "Аймаг байгуулагдсаны 90 жилийн ой, Ардын хувьсгалын 100 жилийн ой угтсан бүтээлч ажил, тохижилт, засвар үйлчилгээ, бүтээн байгуулалт, төсөл арга хэмжээний зардал"-аас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

4. Төсөл арга хэмжээний захиалагчийн техникийн хяналт хийж тайлагнахыг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Жаргалант сумын Засаг дарга Ц.Цогтбаяр нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/148 Ch
02 0938

Аймгийн Засаг даргын
2021 оны 03дугаар сарын 23-ны
өдрийн А/148 дугаар захирамжийн хавсралт

ХОВД ХОТЫН ХУУЧИН НИЙТИЙН ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫН
ГАДНА ФАСАД ЗАСВАР ХИЙХ, НИЙТИЙН ХАЛУУН УС, САУНЫ
ЦОГЦОЛБОРЫН БАРИЛГЫГ ЭХЛҮҮЛЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ

д/д	Төсөл арга хэмжээ нэр	Төсөв өртөг /сая.төг/
Хөрөнгө оруулалтын нийт дүн		400.4
1	72 айлын орон сууцны барилгын гадна фасадны засвар	43.57
2	62 айлын орон сууцны барилгын гадна фасадны засвар	34.88
3	52 айлын орон сууцны барилгын гадна фасадны засвар	29.04
4	3-р 60 айлын орон сууцны барилгын гадна фасадны засвар	32.62
5	Хуучин 1-30 айлын орон сууцны барилгын гадна фасадны засвар	75.14
6	Хуучин 2-30 айлын орон сууцны барилгын гадна фасадны засвар	
7	Хуучин 3-30 айлын орон сууцны барилгын гадна фасадны засвар	
8	Хуучин 4-30 айлын орон сууцны барилгын гадна фасадны засвар	
9	12 айлын орон сууцны барилгын гадна фасадны засвар	23.49
10	12 айлын орон сууцны барилгын гадна фасадны засвар	
11	2-р 60 айлын орон сууцны барилгын гадна фасадны засвар	43.78
12	Усны аж ахуйн 24 айлын орон сууцны барилгын гадна фасадны засвар	
13	48 айлын орон сууцны барилгын гадна фасадны засвар	26.34
14	27 айлын орон сууцны барилгын гадна фасадны засвар	25.08
15	Амарсанаагийн 1 дүгээр гудамжны 105 дугаар байр /24 айл/	16.5
16	Нийтийн халуун ус, сауны цогцолборын барилгыг эхлүүлэх /Жаргалант сум/	50.0

-оОо-